

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ
2024 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	1
1.1. ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ	1
1.2. ХӨРВӨХ ЧАДВАР	2
1.3. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКСҮҮД.....	2
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ	3
2.1. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙЛҮҮЛЭЛТ	3
2.1.1. Хувьцааны арилжаа	3
2.1.2. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа	5
2.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа	5
2.1.4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа	6
2.2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ	6
2.2.1. Хөрөнгө оруулагчдын бүтэц	6
2.3. БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	7
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД.....	8
3.1. Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчид	9
3.2. Мөнгөн хөрөнгийн номинал дансны тайлан	10
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖАА.....	11
4.1. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа	11
4.2. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа	13
ТАВДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ.....	13
5.1. Эрх, зүйн зохицуулалт.....	13
5.2.Гадаадын хөрөнгө оруулагчдыг татах чиглэлээр	13


НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Олон улсын валютын сан, Дэлхийн банкнаас хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хөгжлийн түвшнийг үнэлж, тогтоох хүрээнд хөрөнгийн зах зээлийн хөгжлийн голлох үзүүлэлтүүд болох дараах индикаторуудыг оруулсан байдаг: зах зээлийн үнэлгээ, зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь, хөрвөх чадвар, хувьцааны индекс.

1.1. ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 12.1 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх улиралтай харьцуулахад 7.04 хувиар өссөн, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17.60 хувиар өссөн бөгөөд уг үзүүлэлт нь 2023 оны үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ний 17.18 хувьтай тэнцэж байна.

График 1. ДНБ-д харьцуулсан хөрөнгийн зах зээлийн үнэлгээ



Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээг бүрдүүлж байгаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийт 173 компаниас дараах 30 компанийн зах зээлийн үнэлгээ 11.35 их наяд төгрөгийн үнэлгээтэй байгаа нь хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээний 93.78 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 1. Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 30 компани


№	Компанийн нэр	Эзлэх хувь	№	Компанийн нэр	Эзлэх хувь
1	“ХААН банк” ХК	15.96%	16	“Улсын Их Дэлгүүр” ХК	1.02%
2	“Тавантолгой” ХК	14.12%	17	“Гутал” ХК	0.94%
3	“Худалдаа хөгжлийн банк” ХК	10.26%	18	“Богд банк” ХК	0.85%
4	“АПУ” ХК	8.67%	19	“Лэндмн ББСБ” ХК	0.84%
5	“Голомтбанк” ХК	7.26%	20	“Ард санхүүгийн нэгдэл” ХК	0.63%
6	“Хас банк” ХК	6.62%	21	“Монложистикс холдинг” ХК	0.59%
7	“Инвекор ББСБ” ХК	5.03%	22	“Түмэн шувуут” ХК	0.56%
8	“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” ХК	4.69%	23	“Эм Жи Эл Акуа” ХК	0.49%
9	“Төрийн банк” ХК	2.93%	24	“Монгол шуудан” ХК	0.49%
10	“МИК холдинг” ХК	2.74%	25	“Газар шим үйлдвэр” ХК	0.49%
11	“Премиум нэксус” ХК	1.67%	26	“Тандэм инвест ББСБ” ХК	0.43%
12	“Говь” ХК	1.64%	27	“Мандал даатгал” ХК	0.36%
13	“Монгол даатгал” ХК	1.35%	28	“Инновэйшн инвестмент” ХК	0.35%
14	“Сүү” ХК	1.13%	29	“Улаанбаатар бүк” ХК	0.33%
15	“Монголын хөрөнгийн бирж” ХК	1.07%	30	“Монос Хүнс” ХК	0.32%

Тайлбар: Зах зээлийн үнэлгээнд 100 хувь төрийн өмчит компанийн үнэлгээ ордоггүй болно.

1.2. ХӨРВӨХ ЧАДВАР

Тайлант хугацаанд хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар өмнөх улиралтай харьцуулахад 0.38 пунктээр , өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.54 пунктээр тус тус өсөж, 1.81 хувьд хүрсэн байна. Манай улсын хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар бага байгаа нь хувьцааны хэт төвлөрөлтэй холбоотой юм. Тухайлбал 2024 оны 3 дугаар улирлын байдлаар ТОП-20 индексэд багтах ХК-уудын хувьцааны төвлөрлийг тооцож үзэхэд хэт төвлөрөлтэй буюу нийт хувьцааны 81.44 хувийг 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна.

График 2. Хөрвөх чадвар (хувиар)



1.3. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКСҮҮД

“Монголын хөрөнгийн бирж” ХК-аас ТОП-20, MSE-A, MSE-B гэсэн гурван төрлийн хувьцааны үнийн индексүүдийг тооцон гаргадаг. ТОП-20 индексээр зах зээлийн үнэлгээ болон хувьцаа нь идэвхтэй арилжаалагддаг нэр бүхий 20 компанийн, MSE-A болон MSE-B индексээр үнэт цаасны бүртгэлийн I, II ангилалд багтсан компаниудын хувьцааны үнийн индексийг тус тус харуулдаг байна.

Хүснэгт 2. Индексийн үзүүлэлт

Индекс	2023.III	2024.II	2024.III	Өөрчлөлт /2024.II-2024.III/	Өөрчлөлт /2023.II-2024.II/
ТОП 20	35,436.88	44,385.18	47,864.47	7.84%	35.07%
MSE A	15,249.91	17,223.73	18,360.61	6.60%	20.40%
MSE B	12,197.78	13,387.44	15,410.49	15.11%	26.34%

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

ТОП-20 индексийн дээд үзүүлэлт тайлант хугацааны байдлаар 50,741.39 нэгж, доод үзүүлэлт 40,704.45 нэгж, дундаж үзүүлэлт 44,742.05 нэгж байна. Өмнөх улиралтай харьцуулахад 3,479.29 нэгжээр буюу 7.84 хувиар өсөж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12,427.59 нэгжээр буюу 35.07 хувиар өсөж **47,864.47** нэгж болсон байна.

MSE-A индексийн дээд үзүүлэлт тайлант хугацааны байдлаар 19,385.82 нэгж, доод үзүүлэлт 16,294.41 нэгж, дундаж үзүүлэлт 17,543.88 нэгж байна. Өмнөх улиралтай харьцуулахад 1,136.88 нэгжээр буюу 6.60 хувиар өсөж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,110.70 нэгжээр буюу 20.40 хувиар өсөж, **18,360.61** нэгж болсон байна.

Харин MSE-B индексийн дээд үзүүлэлт 15,444.11 нэгж, доод үзүүлэлт 11,321.67 нэгж, дундаж үзүүлэлт 12,981.61 нэгж байна. Өмнөх улиралтай харьцуулахад 2,023.05 нэгжээр

буюу 15.11 хувиар өсөж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,212.71 нэгжээр буюу 26.34 хувиар өсөж, **15,410.49** нэгж болсон байна.


ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ

2.1. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙЛҮҮЛЭЛТ

2024 оны 3 дугаар улирлын байдлаар нийт **1.06** их наяд төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1.62 дахин өссөн үзүүлэлт бөгөөд өдрийн дундаж арилжаа **5.7** тэрбум төгрөг байна. Нийт арилжааны 998.9 тэрбум төгрөгийн арилжаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар, 59.8 тэрбум төгрөгийн арилжаа хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангаар тус тус хийгдсэн байна.

Тайлант хугацаанд компанийн өрийн хэрэгслийн арилжаа түлхүү явагдсан бөгөөд нийт үнэт цаасны арилжааны 58.44 хувийг компанийн өрийн хэрэгсэл, 23.06 хувийг хувьцаа, 12.44 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 6.07 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа тус тус эзэлж байна.

График 3. Үнэт цаасны арилжааны хэмжээ (бүтээгдэхүүний төрөл, хувиар)




2.1.1. Хувьцааны арилжаа

График 4. Хувьцааны арилжаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд нийт 244.08 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 91.34 хувиар буюу 1.91 дахин буурсан үзүүлэлттэй байна.

Үүнээс хувьцааны анхдагч зах зээлд нийт 24.81 тэрбум төгрөгийн, хоёрдогч зах зээлд нийт 219.27 тэрбум төгрөгийн арилжаа явагдсан байна.



Хоёрдогч зах зээл дээрх хувьцааны арилжааг арилжаа эрхлэх байгууллага дээр бүртгэлтэй, арилжааны хэмжээгээрээ тэргүүлэгч 30 компанийн арилжааны мэдээллийг үнийн дүнгээр харуулбал:

*Хүснэгт 3. Арилжааны хэмжээ хамгийн өндөр 30 компанийн арилжааны үнийн дүн
(тэрбум төгрөгөөр)*

№	Компанийн нэр	Үнийн дүн	№	Компанийн нэр	Үнийн дүн
1	“Говь” ХК	71.52	16	“Голомтбанк” ХК	2.59
2	“Богд банк” ХК	18.58	17	“АПУ” ХК	1.46
3	“Газар шим үйлдвэр” ХК	6.76	18	"Дарханнэхий" ХК	1.38
4	“Премиум нэксус” ХК	6.52	19	“Эм Жи Эл Акуа” ХК	1.33
5	“Монголын хөрөнгийн бирж” ХК	8.87	20	“Улсын Их Дэлгүүр” ХК	1.00
6	“ХААН банк” ХК	4.65	21	“Түмэн шувуут” ХК	0.97
7	“Лэндмн ББСБ” ХК	4.29	22	“Төрийн банк” ХК	0.97
8	“Монложистикс холдинг” ХК	4.26	23	"Бодьдаатгал" ХК	0.93
9	“Ард Кредит ББСБ” ХК	3.77	24	“ОЛЛОО” ХК	0.88
10	“Мандал даатгал” ХК	3.65	25	“Ард санхүүгийн нэгдэл” ХК	0.78
11	“Инновэйшн инвестмент” ХК	3.64	26	“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” ХК	0.63
12	“Сэндли ББСБ” ХК	2.90	27	"Монголбазальт" ХК	0.59
13	"Эрдэнэ сольюшинс" ХК	2.82	28	“Ард даатгал” ХК	0.58
14	“Хас банк” ХК	2.80	29	“Инвескор ББСБ” ХК	0.51
15	“Монос Хүнс” ХК	2.66	30	"Женкотур бюро" ХК	0.33
НИЙТ					98.17

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

Тайлант хугацаанд нийт 20 хувьцаат компанийн 154.94 сая ширхэг буюу 58.13 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий багцын арилжаа хийгдсэн нь нийт хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны 67.9 хувийг эзэлж байна.

Хүснэгт 4. Багцын арилжаа хийгдсэн компаниуд


№	Үнэт цаасны нэр	Арилжаалагдсан ширхэг (мянган ширхэг)	Үнийн дүн (тэрбум төгрөг)
1	“Ард санхүүгийн нэгдэл” ХК	270.00	0.81
2	“Ард кредит ББСБ” ХК	3,222.57	0.34
3	"АПУ" ХК	2,974.82	2.91
4	“Баянгол зочид буудал” ХК	23.90	0.84
5	“Богд банк” ХК	15,971.72	1.35
6	“Премиум нэксус” ХК	27,610.62	4.94
7	“Газар шим үйлдвэр” ХК	40,000.00	2.61
8	“Голомтбанк” ХК	3,405.18	4.78
9	“Инвескор ББСБ” ХК	1,100.66	7.66
10	“Говийн өндөр” ХК	62.67	0.01
11	“ХААН банк” ХК	4,701.11	4.91
12	“Эм Жи Эл Акуа” ХК	2,144.70	0.39
13	“Монложистик холдинг” ХК	18,557.24	3.88
14	"Монгол шуудан" ХК	629.74	0.58
15	“Оллоо” ХК	1,725.31	0.02
16	“Инновэйшн инвестмент” ХК	13,420.19	2.79
17	“Сэндли ББСБ” ХК	13,928.36	2.56
18	“Эрдэнэтхүнс” ХК	368.54	0.97
19	“Худалдаа хөгжлийн банк” ХК	95.56	3.07
20	“Улсын их дэлгүүр” ХК	4,722.35	12.7
НИЙТ		154,935.23	58.13

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

2.1.2. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа

График 5. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд компанийн өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн арилжаагаар 533 тэрбум төгрөгийн, хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 85.70 тэрбум төгрөгийн арилжаа явагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.37 дахин өссөн үзүүлэлт юм.




2.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль батлагдсанаас хойш 2024 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 33 компани хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна.

Тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо 3 компанийн хувийн хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэж, улмаар тус хувийн сангууд үүсгэн байгуулагдсан байна.


График 6. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа (тэрбум төгрөгөөр)



Тайлант хугацаанд хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлд нийт 64.23 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 40.61 хувиар өссөн өссөн дүн юм.

График 7. Тайлант хугацаанд хийгдсэн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжааны задаргаа


Тайлант хугацаанд хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлд нийт 64.23 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэнээс хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангаар 4.5 тэрбум төгрөгийн арилжаа, хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангаар 59.77 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь тус тус нийт арилжааны 6.95 болон 93.05 хувийг бүрдүүлж байна.



2.1.4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа

График 8. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаагаар 100.00 тэрбум төгрөгийн арилжаа, хоёрдогч зах зээлд нийт 31.68 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж, нийт 131.68 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 2.94 дахин буюу 194.42 хувиар өссөн үзүүлэлт юм.




2.2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ

Тайлант хугацаанд **201,922** шинэ данс, **70,949** холболтын данс шинээр нээгдэж өссөн дүнгээр нийт **2,595,216** данс, **661,411** холболтын данс “ҮЦТХТ” ХХК-д бүртгэлтэй байна.

2.2.1. Хөрөнгө оруулагчдын бүтэц

График 9. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын арилжааны үнийн дүнд эзлэх хувь

Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн нийт хоёрдогч зах зээлийн арилжаанд дотоодын иргэний хийсэн арилжаа 94.55 тэрбум төгрөг (28.45 хувь), дотоодын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа 232.12 тэрбум төгрөг (69.84 хувь), гадаадын иргэний хийсэн арилжаа 2.77 тэрбум төгрөг (0.82 хувь), гадаадын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа 2.98 тэрбум төгрөг (0.90 хувь)-ийг тус тус эзэлж нийт 332.4 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.



Эх сурвалж: “МУЦКТ” ХХК

Дээрх арилжаанд давтагдсан тоогоор нийт 95,575 хүн, 1,873 аж ахуйн нэгж оролцож, 248,699 удаагийн арилжаа хийсэн байна. (Дэлгэрэнгүйг доорх хүснэгтээс харна уу.)

Хүснэгт 5. Хөрөнгө оруулагчдын бүтэц (давтагдсан тоо, хувиар)

	Арилжаанд оролцогчийн тоо		Арилжаанд оролцсон тоо	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Гадаадын ААН	114	0.12%	729	0.29%
Гадаадын иргэн	708	0.73%	2,767	1.11%
Дотоодын ААН	1,759	1.81%	13,723	5.52%
Дотоодын иргэн	94,867	97.35%	231,480	93.08%
Нийт	97,448	100%	248,699	100%

Эх сурвалж: “МУЦКТ” ХХК

2.3. БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Биржийн бус зах зээлийн үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс 2024 оны 3 дугаар улирлын байдлаар биржийн бус зах зээлд төгрөгөөр нийт 127 компанийн нийт 3.37 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 233 өрийн хэрэгсэл гарсан бөгөөд 2.68 их наяд төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн.

Мөн доллароор нийт 106.8 сая ам.долларын үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл бүртгэгдсэнээс 66.4 сая ам долларыг амжилттай татан төвлөрүүлсэн байна.

Үүнээс тайлант хугацаанд төгрөгөөр 67 үнэт цаас гаргагчийн 924.5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий, 84 өрийн хэрэгслийг бүртгэсэн бөгөөд нийт 934.74 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 30.3 хувиар өссөн үзүүлэлт юм.

Харин тайлант хугацаанд ам доллароор 23.8 сая ам долларын үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл бүртгэгдсэнээс 20.9 сая ам.долларыг татан төвлөрүүлсэн байна.

График 10. Тайлант хугацаанд ББЗЗ-д бүртгэгдсэн нийт өрийн хэрэгслийн дүн болон бодит татан төвлөрүүлсэн дүн (тэрбум төгрөг, сая ам.доллар)





График 11. Тайлант хугацаанд ББЗЗ-д бүртгэгдсэн нийт өрийн хэрэгслийг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны салбараар ангилсан тоон мэдээлэл (хувиар)

Тайлант хугацаанд бүртгэгдсэн нийт өрийн хэрэгслийн татан төвлөрүүлэхээр зарласан дүнг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны салбараар нь ангилбал банк бус 46 хувь, уул уурхай 37 хувь, борлуулалт 8 хувь, үл хөдлөх 5 хувь, санхүү 1 хувь, худалдаа үйлдвэрлэл 1 хувь, бусад салбар 2 хувийг бүрдүүлж байна.



ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД

Өнөөдрийн байдлаар үнэт цаасны зах зээл дээр Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Инновацийн тухай хууль зэрэг хуулиуд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Эдгээр хууль болон бусад холбогдох дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд хяналт тавих, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлж байна.

Дээрх хууль тогтоомжийн хүрээнд тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл болон бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж буй 303 зохицуулалттай этгээд байна.

Хүснэгт 6. Үнэт цаасны зах зээлд оролцогчид

№	Үйл ажиллагааны төрөл	Тоо
Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэгч		
1	Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага	3
2	Үнэт цаасны клирингийн байгууллага	2 ¹
3	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага	1
4	Үнэт цаасны төлбөрийн байгууллага	1 ²
5	Хөрөнгө оруулалтын менежментийн компани	33
6	Хамтын хөрөнгө оруулалтын сан /хаалттай, нээлттэй/	6
7	Кастодиан банк	3
8	Үнэт цаасны компани	52
	Брокер	51
	Үүнээс:	
	Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэгч	16
	Номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээний үйлчилгээ үзүүлэгч	18
	Дилер	34
	Андеррайтер	24 ³
	Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлэгч	20
9	Хөрөнгө итгэмжлэн удирдагч	8
10	Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч	1
11	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөлтэй компани	63 ⁴
12	ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага	1
13	ХАА-н биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага	9
14	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага	1 ⁵
15	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч /брокер/	11 ⁶
16	Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох байгууллага	3

¹ Тус тоонд үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болох “Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК болон “МУЦКТ” ХХК орсон болно.

² “УЦТХТ” ХХК нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн болон төлбөрийн үйл ажиллагааг үзүүлдэг.

³ Тус тоонд андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 2 банк /“Голомт банк” ХК, “Тээвэр Хөгжлийн банк” ХХК/ орсон болно.

⁴ Тус тоонд “МИК ОССК” ХХК-36, “УЦСК” ХХК-6, “Носк тав ТЗК” ХХК-5, нээлттэй хүрээнд ХБҮЦ гаргасан 15 ТЗК, хаалттай хүрээнд гаргасан 1 ТЗК тус тус орсон.

⁵ Тус тоонд үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болох “Монголын хөрөнгийн бирж” ХК орсон болно.

⁶ Нэр бүхий 8 үнэт цаасны компани тус үйл ажиллагааг давхар эрхлэн гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг авсан.

Бүртгэлтэй хөндлөнгийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд		
17	ҮЦЗЗ-д оролцогчид аудитын үйлчилгээ, хөрөнгийн үнэлгээ үзүүлэгч байгууллага	70 ⁷
	Аудитын үйлчилгээ үзүүлэгч байгууллага	52
	Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч байгууллага	25
18	ҮЦЗЗ-д оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэгч байгууллага	44
Нийт (ГЗ болон бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж буй компаниудын тоо)		303

Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийт 173 ХК байна. Мөн Хорооны 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 273 дугаар тогтоолоор “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо” ГҮТББ-ыг, 2015 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 379 дүгээр тогтоолоор “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийг өөрийгөө зохицуулах байгууллагаар тус тус бүртгэсэн.


Хүснэгт 7. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй ХК-ийн тоо болон зах зээлийн үнэлгээ

Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын нэр	Бүртгэлтэй ХК-ийн тоо	Зах зээлийн үнэлгээ 2024.II
1) “Монголын хөрөнгийн бирж” ХК -100 хувь төрийн өмчит -Төрийн өмчийн оролцоотой -Бусад	171 3 11 157	12,084,155,033,728.70 ₮ (Тус биржийн зах зээлийн үнэлгээнд 100 хувь төрийн өмчит компанийн үнэлгээ ордоггүй болно.)
2) “Улаанбаатар үнэт цаасны бирж” ХК	2	17,988,769,050 ₮
3) “Чингис хаан хөрөнгийн бирж” ХХК	-	-

3.1. Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчид

График 12. Үнэт цаасны салбарын нийт хөрөнгө (хувиар)

Тайлант хугацаанд үнэт цаасны салбарын нийт хөрөнгийн хэмжээг үнэт цаасны компаниуд, хамтын хөрөнгө оруулалтын сангууд болон хөрөнгө оруулалтын менежментийн компаниудын нийт хөрөнгөөр тооцоход 648.8 тэрбум төгрөг байна. Үүний 60.5 хувийг үнэт цаасны компаниуд, 21.2 хувийг хөрөнгө оруулалтын менежментийн компаниуд, 18.3 хувийг хамтын хөрөнгө оруулалтын сангуудын хөрөнгө тус тус бүрдүүлж байна.



2024 оны 3 дугаар улирлын байдлаар Хороонд бүртгэлтэй 52 үнэт цаасны компани байгаагаас үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл болон бусад хавсран эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж байгаа 51 үнэт цаасны компаниудын нийт хөрөнгө 392.7 тэрбум, нийт орлого 49.9 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх улирлаас 77.03, 46.02 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Тус компаниудыг нийт хөрөнгийн хэмжээ болон нийт орлогын хэмжээгээр нь ангилан үзвэл дараах бүтэцтэй байна.

⁷ ҮЦЗЗ-д оролцогчид аудитын үйлчилгээ, хөрөнгийн үнэлгээ үзүүлэх үйлчилгээг зэрэг үзүүлдэг 7 компани байна.

Хүснэгт 8. Үнэт цаасны компаниудын хөрөнгийн болон орлогын шатлалын бүтэц

Нийт хөрөнгө	Компаниудын тоо	Нийт орлого	Компаниудын тоо
0 – 100,000,000	5	0 – 100,000,000	34
100,000,001 -1,000,000,000	22	100,000,001 - 1,000,000,000	4
1,000,000,001 ба түүнээс дээш	24	1,000,000,001 ба түүнээс дээш	13

2024 оны 3 дугаар улирлын байдлаар Хороонд бүртгэлтэй 33 хөрөнгө оруулалтын менежментийн компани байна. Тус компаниудын хувьд 41 хувийн хөрөнгө оруулалтын сан, 6 хамтын хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр удирдан ажиллаж байна.

Хөрөнгө оруулалтын менежментийн компаниудын нийт хөрөнгө 137.6 тэрбум, нийт орлого 12.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх улирлаас 65.03, 69.18 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Тус компаниудыг нийт хөрөнгийн хэмжээ болон нийт орлогын хэмжээгээр нь ангилан үзвэл дараах бүтэцтэй байна.

Хүснэгт 9. Хөрөнгө оруулалтын менежментийн компаниудын хөрөнгийн болон орлогын шатлалын бүтэц

Нийт хөрөнгө	Компаниудын тоо	Нийт орлого	Компаниудын тоо
0 – 100,000,000	8	0 – 100,000,000	28
100,000,001 -1,000,000,000	16	100,000,001 - 1,000,000,000	3
1,000,000,001 ба түүнээс дээш	9	1,000,000,001 ба түүнээс дээш	2

2024 оны 3 дугаар улирлын байдлаар Хороонд бүртгэлтэй 6 хамтын хөрөнгө оруулалтын сан байгаагаас 3 нь хамтын нээлттэй, 2 нь хамтын хаалттай, 1 хамтын хаалттай биржээр арилжаалагдах сан хэлбэртэйгээр үйл ажиллагаа эрхэлж байна.

Хөрөнгө оруулалтын сангуудын нийт хөрөнгө 118.5 тэрбум, нийт орлого 11.0 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх улирлаас 26.71, 1.10 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Тус компаниудыг нийт хөрөнгийн хэмжээ болон нийт орлогын хэмжээгээр нь ангилан үзвэл дараах бүтэцтэй байна.

Хүснэгт 10. Хөрөнгө оруулалтын хамтын сангуудын хөрөнгийн болон орлогын шатлалын бүтэц

Нийт хөрөнгө	Хамтын сангуудын тоо	Нийт орлого	Хамтын сангуудын тоо
0 – 100,000,000	-	0 – 100,000,000	2
100,000,001 -1,000,000,000	2	100,000,001 - 1,000,000,000	2
1,000,000,001 ба түүнээс дээш	4	1,000,000,001 ба түүнээс дээш	2

3.2. Мөнгөн хөрөнгийн номинал дансны тайлан

2024 оны 3 дугаар улирлын байдлаар Хороонд бүртгэлтэй номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээний

үйлчилгээ үзүүлэгч 20 компани байна. Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс мөнгөн хөрөнгийн номинал дансны тайланг цахимаар хүлээн авахтай холбоотойгоор холбогдох ажлыг хийж гүйцэтгэснээр энэ оны эхний улирлаас компаниуд тайлангаа цахимаар ирүүлэх боломжтой болсон бөгөөд тайлант хугацаанд нийт 19 компани тайлангаа ирүүлсэн байна.


Тайлант хугацаанд дээрх 19 компанид бүртгэлтэй нийт 1,652,424 харилцагч байгаагаас 54,946 харилцагч үйлчилгээ авч, 397.9 тэрбум төгрөгийн болон 16.8 сая ам.долларын гүйлгээ хийсэн байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖАА

4.1. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа

График 13. ХААБ-ээр арилжаалагдсан түүхий эдийн арилжаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд Хөдөө аж ахуйн бирж нь 157 удаагийн цахим арилжаа зохион байгуулан 862 хэлцлээр нийт 943.1 тэрбум төгрөгийн үнэ бүхий бараа, түүхий эдийн арилжаа хийсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 118.54 тэрбум төгрөгөөр буюу 14.38 хувиар өссөн үзүүлэлт юм.



ХААБ-ээр дараах төрлийн бүтээгдэхүүнүүд арилжаалагдсан байна. Үүнд:

Зураг 1. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа



Хүснэгт 11. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны дүн (бүтээгдэхүүний төрлөөр)

Ямааны ноолуур	850,998,135,136	Нийт арилжааны дийлэнх хувийг буюу 90.230 хувийг ямааны ноолуур, 7.077 хувийг ямааны завод ноос, 1.340 хувийг тэмээний ноос, 0.975 хувийг хонины ноос, 0.375 хувийг тосны ургамал, 0.003 хувийг хонины завод ноос тус тус эзэлж байна.
Хонины ноос	9,198,880,000	
Ямааны завод ноос	66,743,047,000	
Хонины завод ноос	29,150,000	
Тэмээний ноос	12,597,320,000	
Тосны ургамал (рапс)	3,540,900,000	
Нийт	943,107,432,136.00	


4.2. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа

2024 оны 3 дугаар улирлын байдлаар 247 удаагийн арилжаагаар 17.80 сая тонн нүүрсийг 6.97 их наяд төгрөгөөр, 198 удаагийн арилжаагаар 1.78 сая тонн төмрийн хүдэр, баяжмалыг 423.63 тэрбум төгрөгөөр, 4 удаагийн арилжаагаар 15,405 тонн хайлуур жоншийг 8.12 тэрбум төгрөгөөр, 2 удаагийн арилжаагаар 6,000 тонн зэсийн баяжмалыг 40.5 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалж, нийт **451** удаагийн арилжаагаар **19.60** сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг **7.44** их наяд төгрөгөөр арилжаалсан ба өдрийн дундаж арилжаа **42.99** тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үед хийгдсэн арилжаанаас 2.6 дахин өссөн үзүүлэлт юм.

Тухайлбал өмнөх оны мөн үед 117 удаагийн арилжаагаар 7.6 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг арилжаалсан.

График 14. Нийт арилжаалагдсан нүүрсний хэмжээ (төрөл, ангилал, хувиар)


- 1/3 коксжих нүүрс
- Баяжуулсан коксжих нүүрс
- Баяжуулсан дунд зэрэг үнстэй хагас хатуу коксжих нүүрс
- Баяжуулсан сул коксжих нүүрс
- Дэгдэмхий бодис дундаас их, хийн нүүрс
- Дэгдэмхий бодис дунд, коксжих нүүрс
- Дэгдэмхий бодис их, хийн нүүрс
- Эрчим хүчний нүүрс
- Чийг багатай хүрэн нүүрс



Тайлант хугацаанд нийт 9 төрлийн 17.80 сая тонн нүүрс арилжаалагдсанаас 1/3 коксжих нүүрс 40.24 хувийг, баяжуулсан коксжих нүүрс 11.72 хувийг, баяжуулсан дунд зэрэг үнстэй хагас хатуу коксжих нүүрс 10.68 хувийг, баяжуулсан сул коксжих нүүрс 0.36 хувийг, дэгдэмхий бодис дундаас их, хийн нүүрс 1.44 хувийг, дэгдэмхий бодис дунд, коксжих нүүрс 23.70 хувийг, эрчим хүчний нүүрс 11.51 хувийг, чийг багатай хүрэн нүүрс 0.29 хувийг, дэгдэмхий бодис их, хийн нүүрс 0.07 хувийг тус тус эзэлж байна.

График 15. Нийт арилжаалагдсан төмрийн хэмжээ (төрөл, ангилал, хувиар)

Тайлант хугацаанд нийт 1.78 сая тонн төмрийн хүдэр, баяжмал арилжаалагдсанаас 35.73 хувийг Fe-52%-ийн агууламжтай төмрийн хүдэр, 51.84 хувь Fe-58%-ийн агууламжтай төмрийн баяжмал, 12.43 хувийг Fe-65%-ийн агууламжтай төмрийн баяжмал тус тус бүрдүүлж байна.



ТАВДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооноос 2024 оны гуравдугаар улирлын байдлаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний тоо хэмжээг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн зах зээл дэх оролцоог нэмэгдүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах чиглэлд голчлон анхаарч дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

5.1. Эрх, зүйн зохицуулалт

УИХ-аас Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр эцэслэн баталсан.

Хууль батлагдсантай холбоотойгоор Хорооны зүгээс шинээр болон нэмэлт, өөрчлөлт оруулахаар зохицуулсан дараах холбогдох журмын төслүүдийг боловсруулж, Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-т заасны дагуу Хорооны цахим хуудсанд байршуулан олон нийтээс санал авч байна. Үүнд:

- Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификатыг бүртгэх, арилжих, тайлагнах журам
- Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бусдад бэлэглэх, өвлүүлэх тухай журам
- Хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэх, хадгалах, арилжих, өмчлөх эрх шилжүүлэх журам
- Үнэт цаас зээлдүүлэх тухай журам
- Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааг эрхлэх этгээдийн үйл ажиллагаа, түүний программ хангамжид тавих нөхцөл, шаардлагыг тогтоох тухай журам
- Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам

- Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам
- Хувьцаат компанийн хувьд ногдол ашиг хуваарилах журам
- Мэргэшлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох болон үйл ажиллагааг зохицуулах журам

5.2. Гадаадын хөрөнгө оруулагчдыг татах чиглэлээр

Хорооны зүгээс гадаадын хөрөнгө оруулагчдыг татах хүрээнд олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, нэн ялангуяа хөрөнгийн зах зээлийг гадаадын хөрөнгийн зах зээлтэй холбох, хөрөнгө оруулагч нарт сурталчлах, дотоодын аж ахуйн нэгжүүдийг олон улсын зах зээлээс хөрөнгө оруулалт татахад дэмжлэг үзүүлэх чиглэлд онцгой анхаарал хандуулан ажиллаж байна.

Тухайлбал олон улсын зохицуулагч байгууллагуудтай хамтын ажиллагаагаа тэлэх, Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг олон улсад таниулан сурталчлах чиглэлээр цуврал арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажиллаж байна. Тухайлбал, өнгөрсөн жил “Mongolian capital markets day-2023” арга хэмжээг БНХАУ-ын Шанхай хотод, “Mongolia’s Capital Market Connectivity” арга хэмжээг БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконгд зохион байгуулсан бол энэ оны 04 дүгээр сард “Монголын хөрөнгө оруулалтын долоо хоног” арга хэмжээг Америкийн Нэгдсэн Улсын Нью-Йорк хотноо зохион байгуулаад байна.

Тус арга хэмжээгээр дамжуулан
гадаадын хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгч
болон бусад зах зээлийн оролцогч нарт
Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн
өнөөгийн нөхцөл байдал болон арга хэмжээ

зохион байгуулж буй улс дахь хөрөнгийн
бирж дээр үнэт цаас гаргах, давхар
бүртгүүлэх боломжийн талаар мэдээлэл
түгээх зорилготой юм.

ҮНЭТ ЦААСНЫ ГАЗАР

---o-0-o---